

2020. 03. 27

№ 248

таний \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” -Д

## Мэдээлэл хүргүүлэх тухай

Монос Хүнс ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 04 сарын 06 өдрийн 14 цагаас хуралдахаар товлогдсон билээ.

Улсын онцгой комиссын 2020 оны 03 сарын 20 өдрийн 13 дугаар тогтоолоор COVID-19 цар тахлын өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үүднээс улсын хэмжээнд тогтоосон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 04 сарын 30 өдрийг дуустал сунгаж, энэ хугацаанд олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хориглоод байгаа тул манай компани Монгол улсын Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэр, тогтоолыг биелүүлэн ажиллах үүргийн хүрээнд компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын товыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулахаар ТУЗ-ийн хурлаараа хэлэлцэн шийдвэрлэсэн юм.

Иймд Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдал болон олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах хориг дуусгавар болмогц Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын товыг шинээр товлож, хувьцаа эзэмшигч наарт хүргүүлэн ажиллахаар болсныг энэхүү албан бичгээр мэдэгдэж байна.

Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2020 оны 3-р сарын 05-ны өдөр гаргасан Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр хийх уриалгыг манай компани дэмжин ажиллахаар төлөвлөн, хурлыг цахим хэлбэрээр хийх бэлтгэл ажлыг эхлүүлээд байна. Хурлыг цахим хэлбэрээр хийх талаар СЗХ-оос чиглэл зөвлөмж ирүүлэхийг хүсэн хандсан бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлын хугацаа товлогдмогц хүргүүлэх болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



А. ОТГОНДАРЬ



+976 77773525

foods@monos.mn  
www.monosfoods.mnЧингисийн өргөн чөлөө 205/2, Хан-Уул дүүрэг,  
Улаанбаатар хот 17043, Монгол Улс